



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 04 өдөр

Дугаар 8/118

Батноров сум

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын Зөвлөлийн хурлын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн шийдвэрийн дагуу Дундбүрд 6 дугаар багийн иргэн Ганхуяг овогтой Гэрэлмаагийн сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэн 500,000 (Таван зуун мянган) төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.
2. Буцалтгүй тусламж болох 500,000 (Таван зуун мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Б.Энхжаргал)-д үүрэг болгосугай.



Б.ЖАВХЛАНБАЯР

230423249